



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/269

Арвайхээр

Комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн дуудлага худалдааг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: М.Нинжбадгар –аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Хөтлөгч: Б.Дэлгэрмаа -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын санхүү, өмчийн хадгалалт хамгаалалт, хариуцсан мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: М.Мөнхнасан -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Архив, бичиг хэрэг, нярав

Гишүүд: Д.Мөнхцэцэг –аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Идэрсайхан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2.Дуудлага худалдааг хуулийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (М.Нинжбадгар)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100597